

Аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2015 оны жилийн эцсийн байдлаар)

I. Төсвийн орлого



Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээгээр 2015 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 114,7 хувьтай буюу 4756,5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүний гадна улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын төлөвлөгөө 134,2 хувьтай буюу 2527,3 сая төгрөгийн орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулаад байна. Улсын болон орон нутгийн төсөвт нийт дүнгээр 7283,8 сая төгрөгийн орлого оруулж, аймгийн дүнгээр орлогын төлөвлөгөөний биелэлт 120,8 хувьтай байна.

Тусламжийн орлогыг оруулан тооцоноор аймгийн хэмжээний нийт орлого ба тусламж 36647,6 сая төгрөг болж, төлөвлөгөөний биелэлт 98 хувьтай байна. Орон нутгийн төсөвт улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг 7549,5 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 20563,9 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээс 3777,7 саятөг нийт 31891,1 сая төгрөгийн тусламжийн орлого орсон байна.

Орон нутгийн төсвийн орлогынхоо төлөвлөгөөг Өндөршил, Говь-Угтаал, Өлзийт, Дэлгэрхангай, Сайхан-овоо Эрдэнэдалай сумд 1,5-55,6 хувиар буюу 1605,7-127407,2 мянган төгрөгөөр төлөвлөгөөгөө тасласан бол бусад бүх сумд төлөвлөгөөгөө 1,7-245,7 хувиар давуулан биелүүлсэн байна.

II. Төсвийн зарлага



2015 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн төсвийн байгууллагын зардлын дүн 39752,1 сая төгрөг болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,4 хувиар өссөн байна. Зардлын төрлөөр авч үзвэл цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал 18309,5 сая төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 9,3 хувиар өсөж нийт зардлын 46,1 хувийг эзэлж байна. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл өмнөх оноос 8,8 хувиар өсч 1988,5 сая төгрөг болсон байна. Мөн байр ашиглалттай холбоотой бусад зардал өмнөх оноос

22,8 хувиар өсч 2596,1 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 607,1 сая болж өмнөх оноос 5,6 хувиар тус тус өссөн бол, бусад бүх зардал 4,0-57,1 хувиар буурсан байна. Өмнөх онтой харьцуулахад хамгийн их буурсан зардал эд хогшил урсгал засварын зардал 57,1 хувиар буурсан бол хангамж бараа материалын зардал 17,8 хувиар, хөрөнгийн зардал 11,4 хувиар, томилолтын зардал 12,2 хувиар тус тус буурсан харагдаж байна.



III. Банк

Банкны зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 4.0 хувиар өсч 74510.5 сая төгрөг болов. Үүнээс хугацаа хэтэрсэн зээл 245.2 сая төгрөг болж өссөн бол чанаргүй зээл 278.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оны мөн үеэс 2.9 дахин өссөн байна. Нийт зээлийн үлдэгдлийн 0.7 хувийг хугацаа хэтэрсэн ба чанаргүй зээл эзэлж байна. Иргэдийн хувийн хадгаламж өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар өсч 27036.3 сая төгрөг болов.

IV. Хүн амын зарим үзүүлэлтүүд



2015 онд хүн орон сууцны завсрын тооллого явагдаж хүн амын тоог өрхийн мэдээллийн сангаас гаргахаар болсон. Суурийн хүн амын мэдээг урьдчилсан байдлаар гаргаж танилцуулж байна. 2015 оны жилийн эцсийн байдлаар аймгийн нийт хүн ам 44925 болж өмнөх оноос 718 хүнээр буюу 1,6 хувиар өссөн байна. Хулд ,Луус, Сайхан-Овоо , Адаацаг, Өндөршил сумдын хүн ам өмнөх оноос 0,6-1,2 хувиар буурсан бол бусад сумдын хүн ам 0,1-4,2 хувиар өссөн байна. Нийт хүн амын 21906 нь буюу 48,9 хувийг эмэгтэйчүүд 51,1 хувийг эрчүүд эзэлж байна. 100 болон түүнээс дээш настай 4 хүн байгаагийн 3 нь эмэгтэй байна. Өрхийн тоо 13885 болж өмнөх оноос 437–аар буюу 3,2 хувиар өссөн байна. Өрхийн тоо өссөнөөр нэг өрхөд ногдох хүн амын тоо буурч 3,2 болсон байна.

Хүн амын ердийн хөдөлгөөний ХА-1 мэдээгээр 2015 онд 1095 хүүхэд шинээр мэндэлж өмнөх оноос 64 хүүхдээр буюу 6,2 хувиар өссөн байна. Шинээр мэндэлсэн хүүхдийн 559 нь эрэгтэй 536 нь эмэгтэй хүүхэд байна. Амаржсан эхчүүдийн 1004

нь буюу 91,6 хувь нь бүрэн бус дундаас дээш боловсролтой, 8,3 хувь нь бага болон боловсролгүй байна. Мөн нийт амарсан эхчүүдийн 51,7 буюу 566 нь батлуулсан гэр бүлтэй, 345 буюу 31,5 хувь нь батлуулаагүй гэр бүлтэй, 184 нь гэр бүлгүй эмэгтэйчүүд байна.

2014 оны байдлаар нийт 182 гэр бүл шинээр бүртгэгдсэний 80,7 хувь нь 18-29 насны залуучууд байна. Тухайн онд 19 гэр бүл гэрлэлтээ цуцлуулсан нь өмнөх оноос 51,2 буюу 20 –р буурсан байна. Үүний 11 нь 4-9 жил хамт амьдарсан гэр бүл, 8 нь 10-с дээш жил хамт амьдарсан гэр бүл байсан байна.

Өнгөрсөн оны байдлаар 316 хүн нас барсан бөгөөд өмнөх оноос 46 хүнээр буюу 17 хувиар өссөн байна. Нийт нас баралтын 61,4 хувийг эрэгтэйчүүд 38,6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Нийт нас баралтын 53,8 хувь буюу 170 хүн нь 60 болон түүнээс дээш насныхан байна. Тухайн онд 13 хүүхэд бусдад үрчлэгдсэний 5 нь эмэгтэй 8 нь эрэгтэй хүүхэд байна. Насны бүлгээр авч үзвэл нийт хүүхдүүдийн 9 нь 0-3 настай, 2 нь 3-6 насны, 2 нь 7-с дээш насны хүүхэд байна.

Хүн амын шилжилт хөдөлгөөний мэдээгээр 2015 онд манай аймагт 792 хүн шилжин ирж өмнөх оноос 123 хүнээр өссөн байна. Шилжин ирсэн нийт хүн амын 66,5 хувь буюу 527 нь насанд хүрэгчид, 265 нь буюу 33,5 хувь нь 16-аас доош насны хүүхэд байна. Шилжин явсан хүн амын тоо 1152 болж өмнөх оноос 298 хүнээр буурсан байна. Шилжин явсан нийт хүн амын 849 нь буюу 73,7 хувь нь насанд хүрэгчид байгаа бол 26,3 нь буюу 303 нь 16 хүртлэх насны хүүхэд байна.

2015 оны жилийн эцсийн байдлаар тус аймгийн хувьд 32 бүтэн өнчин хүүхэд, 438 хагас өнчин хүүхэд бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 1,0 хувиар буурсан байна. Нийт өнчин хүүхдүүдийн 5.1 хувийг 0-4 насны хүүхэд, 21,3 хувийг 5-9 насныхан, 36.0 хувийг 10-14 насныхан, үлдсэн 37.6 хувийг 15-с дээш насны хүүхдүүд эзэлж байна.

18 хүртлэх насны хүүхэдтэй өрх толгойлсон хүний тоо 938 болж өмнөх оны мөн үеэс 24.5 хувиар буурсан бол эдгээрийн 88,1 хувь нь эмэгтэйчүүд 11,9 хувь нь эрэгтэйчүүд

байна. Нийт өрх толгойлсон хүмүүсийн 642 нь 1-3 хүүхэдтэй, 224 нь 3-5 хүүхэдтэй, 72 нь 6 болон түүнээс дээш хүүхэдтэй байна. Аймгийн хэмжээнд ихэр хүүхэдтэй өрх 110 байна. Ганцаар биеэр амьдарч байгаа ахмад настаны тоо 1015 байгаа бол эдгээрийн 758 нь 55-с дээш насны эмэгтэйчүүд 257 нь 60-с дээш насны эрэгтэйчүүд байна.

Жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо 1837 болж өмнөх оны мөн үеэс 7,3 хувиар буурсан байна. Эдгээрийн 43,2 хувь буюу 794 нь эмэгтэйчүүд эзэлж байна.

V. Бүртгэлтэй ажилгүй иргэн



2015 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй, ажил идэвхитэй хайж байгаа 749 хүн бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 237 хүнээр өссөн байна. Нийт ажилгүйчүүдийн 49.1 хувь буюу 368 хүн нь эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд 254 ажилгүйчүүд ногдож байхад Гурвансайхан /515/, Баянжаргалан /403/, Говь-Угтаал /361/, Эрдэнэдалай /326/ байгаа нь аймгийн дундажаас дээгүүр байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 0.1 хувь нь магистер, 20.4 хувь нь дипломын болон баклавын дээд, 5.2 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 12 хувь нь техникийн болон мэргэжлийн, 33.6 хувь нь бүрэн дунд, 17.9 хувь нь суурь, 8 хувь нь бага, 2.8 хувь нь боловсролгүй иргэд байна.

VI. Ажлын байрны зуучлал




Хөдөлмөрийн хэлтсийн 2015 оны 12 сарын мэдээгээр энэ онд нийт 536 хүн ажлын байранд зуучлагдан орсон нь өнгөрсөн оны мөн үеэс 324 хүнээр буурсан байна. Ажлын байранд зуучлагдан ажилд орсон ажиллагчдыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд 35.4 хувь нь боловсруулах аж үйлдвэрийн салбар, 25.4 хувь нь ХАА ан агнуур ойн аж ахуй, 8.6 хувь нь төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, 6.7 хувь нь боловсрол, 5.8 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 18.1 хувь нь бусад салбарт ногдож байна.

VII. Нийгмийн даатгал




Аймгийн нийгмийн даатгалын сангийн орлого 2015 оны жилийн эцсийн байдлаар 24422,8 сая төгрөг, зарлага 24707,0 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 3244,3 сая төгрөг буюу 15,3 хувь, зарлага 3112,0 сая төгрөг буюу 14,4 хувиар өслөө.

Аймгийн нийгмийн даатгалын сангийн орлого, жил бүрийн эхний 12 сарын байдлаар, /сая төгрөг/



Аймгийн нийгмийн даатгалын сангийн зарлага, жил бүрийн эхний 12 сарын байдлаар, /сая төгрөг/



Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалд энэ онд 10253 хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 2319 хүн буюу 22,6 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагаас, 4083 хүн буюу 39,8 хувь нь төсөвт байгууллагаас, 3851 хүн буюу 37,6 хувь нь сайн дураар шимтгэл төлсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулж үзэхэд бүгд буурсан байна.

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 2015 оны жилийн эцсийн байдлаар 19564,9 сая төгрөг болж, үүний 80,6 хувийг өндөр настны, 13,7 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 2,9 хувийг тэжээгчээ алдсаны, 2,8 хувийг цэргийн тэтгэвэр эзэлж байна.

Энэ оны эцсийн байдлаар тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч 6292 хүн байна. Нийт тэтгэвэр авагчдын 79.9 хувь буюу 5024 хүн өндөр насны, 14,9 хувь буюу 940 хүн тахир дутуугийн, 3,5 хувь буюу 223 хүн тэжээгчээ алдсаны, 1.7 хувь буюу 105 хүн нь цэргийн тэтгэвэр авагчид байна.

2015 оны жилийн эцсийн байдлаар тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авагчид 2102, ҮОМШӨ-ний

даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авагчид 21, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авагчид 165 хүн байна. Мөн Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо 35753 байгаагийн 75,6 хувь буюу 27013 төр хариуцах иргэд, 13,9 хувь буюу 4972 малчид, 10,5 хувь буюу 3768 оюутан суралцагсад, аж ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн байна.

2015 оны эцсийн байдлаар аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 8911,3 сая төгрөг болж төлөвлөгөөгөө 1,1 хувиар буюу 94,7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөгөө Гурвансайхан, Цагаандэлгэр, Адаацаг, Сайнцагаан сумаас бусад сумд 1,0-10,4 хувиар буюу 2,1-27,4 сая төгрөгөөр тасалсан байна.

VIII. Эрүүл мэнд



Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 2015 оны жилийн эцсийн байдлаар төрөлт нэмэгдсэн ба нийт төрсөн эхчүүдийн 82,8 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн байна. Энэ онд эхийн эндэгдэл гараагүй.

2015 оны жилийн эцсийн байдлаар нялхсын эндэгдэлийн 7 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 9 тохиолдлоор буурч, 1000 амьд төрөлтөд 7,0 ногдож байна. Харин 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 3 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийн түвшинд буюу Хулд суманд 1 хүүхэд өвчнөөр, Луус, Говь-Угтаал суманд тус бүр нэг нэг хүүхэд ослын улмаас эндсэн байна.



Эрүүл мэндийн газрын мэдээгээр нас баралтын 260 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өнгөрсөн оноос 28 тохиолдлоор нэмэгдэж, нийт нас барсан хүний 15.0 хувь буюу 39 хүн эмнэлэгт нас барсан байна. Нас баралтыг шалтгаанаар нь авч үзвэл хорт хавдрын нас баралт хамгийн өндөр 26,5 хувийг эзэлж байна. Мөн осол гэмтлийн шалтгаант нас баралтын тохиолдол 44 гарч, нийт нас баралтын 16,9 хувийг эзэлж байна. Осол гэмтлийн шалтгаант нас баралтыг бүтцээр нь авч үзвэл амиа хорлосон 11, бусдад хорлогдсон 1, зам тээврийн осол 16 бусад осол 16 байна.


2015 оны жилийн эцсийн байдлаар стационарит шинээр 10010 эмчлүүлэгч хэвтэж 10081 эмчлүүлэгч эмнэлгээс гарсан бөгөөд нийт 71330 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7,1 байна.

Энэ оны байдлаар 173230 үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 34,4%, амбулаторийн үзлэг 42,6 %, идэвхитэй хяналт 15,3 %, гэрийн үзлэг 7,7 %- ийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 38.5 хувь нь эрэгтэй, 61,5 хувь нь эмэгтэй хүн байна.

2015 оны байдлаар хорт хавдрын 107 өвчлөлийн тохиолдол шинээр бүртгэгдэж, хорт хавдрын хяналтанд байгаа хүмүүсээс 69 хүн нас барсан байна.

Аймгийн хэмжээнд жилийн эцсийн байдлаар халдварт өвчний 512 тохиолдол бүртгэгдээд байгаа нь урьд оны мөн

үеэс 172 тохиолдлоор нэмэгдэж, 10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 115,6 болж өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн байна.



Халдварт өвчнийг бүтцээр нь авч үзвэл вируст гепатит 1,5 хувь, бэлгийн замын халдвар 32,6 хувь, Амьсгалын замын халдвар 51,4 хувь, сүрьеэ 3,1 хувь, гар хөл, амны өвчин 5,7 хувь, гэдэсний халдварт өвчин 4,5 хувь, бусад өвчлөл 1,2 хувийг тус тус эзэлж байна.


Эндээс харахад амьсгалын замын халдварт өвчин дийлэнх хувийг эзэлж байна. Салхин цэцэг, сүрьеэ, ёлом, гахай хавдар, халдварын гаралтай суулгалт, цусан суулга, гонококкт халдвар зэрэг халдварт өвчний тохиолдол буурсан боловч, Дэлгэрцогт, Говь-Угтаал, Өндөршил, Гурвансайхан, Өлзийт, Хулд, Луус, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Адаацаг, Сайнцагаан сумдад улаан бурхан өвчний 235 тохиолдол, Сайнцагаан суманд улаанууд өвчний 1 тохиолдол, улаан эсэргэнэ өвчний 2 тохиолдол, Дэлгэрцогт, Өлзийт, Сайнцагаан суманд гар хөл амны өвчний 29 тохиолдол, Гурвансайхан суманд бруцеллэз өвчний 1 тохиолдол, Дэлгэрцогт суманд цусан суулга өвчний 1 тохиолдол, Луус, Цагаандэлгэр суманд гахай хавдар өвчний 1

тохиолдол, Сайнцагаан суманд бактерийн гаралтай хоолны хордлогын 22 тохиолдол тус тус шинээр бүртгэгдсэн байна.


XI. Хөдөө аж ахуй



2015 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 2764.4 мянган толгой мал тоологдсон нь өмнөх оноос 328.7 мянган толгой буюу 13.5 хувиар өсч, тэмээ 30.8 мянга, адуу 123.7 мянга, үхэр 55.0 мянга, хонь 1266.2 мянга, ямаа 1288.7 мянган толгой болж, таван төрөл дээрээ өссөн байна.



Аймгийн нийт сум буюу 15 сум 100.0 мянгаас дээш толгой малтай байгаагийн дотор Эрдэнэдалай сум хамгийн олон буюу 422.1 мянган толгой мал тоолуулсан бол хамгийн цөөхөн мал тоолуулсан Баянжаргалан сум 108.3 мянган толгой мал тоолуулав




Аймгийн хэмжээнд нийт 6181 малчин өрхийн 11633 малчид байгаагаас 45.3 хувь буюу 5274 нь эмэгтэйчүүд байна. Нийт малчдын 15-35 насны малчин 3868 буюу 33.3 хувь, 35-59 насны малчин 6427 буюу 55.2 хувь, 60-аас дээш насны малчид 1339 буюу 11.5 хувийг тус тус эзэлж байна

Мянгаас дээш малтай малчин өрхийн тоо энэ онд 524 болж, өмнөх оноос 25.7 хувиар өссөн байна. Үүний дотор хоёр мянгаас дээш малтай малчин 36 байгаагийн гадна Эрдэнэдалай 59, Гурвансайхан 57, Говь-Угтаал 52, Сайнцагаан 52 мянгат малчидтай болж аймагтаа мянгат малчдын тоогоор тэргүүлж байна


Оны эхний эх малын 95.2 хувь нь төллөж, гарсан төлийн 99.4 хувь нь бойжсон байна. Энэ онд оны эхний малын 0.1 хувь буюу 3800 том мал хорогдов. Үүний дотор оны эхний тэмээний 0.2 хувь, адууны 0.1 хувь, үхрийн 0.3 хувь, хонины 0.1 хувь, ямааны 0.2 хувь нь хорогджээ

Малчин өрхийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлт 2015 оны мал тооллогын дүнгээр 5139 өрх нь цахилгаан үүсгүүртэй, 4676 өрх телевизортой, 3484 өрх радио, 4117 өрх оёдлын машинтай, 5072 өрх гар утас ашиглаж байна.




Ургац: 2015 онд нийт 29,6 га-с 110,2 тн төмс, 14,4 га-с 45,1тн хүнсний ногоо, 25 га-с 30тн тэжээлийн ургамал хураан авч, өөрийн хүчээр 98,5тн өвс, 7603,6тн гар тэжээл, хужир шүү бэлтгэсэн байна.

Х.Барилга

 Аймгийн дүнгээр энэ онд 20,024.0 сая төгрөгийн барилга угсралтын ажил, 1,022.2 сая төгрөгийн их засварын ажил хийгдсэн нь өмнөх оныхтой харьцуулахад 81,3 хувьтай байна. Энэ онд 957,7 сая төгрөгийн орон сууцны барилга, 1,436,7 сая төгрөгийн худалдаа үйлчилгээний зохиулалттай барилга, 861,0 сая төгрөгийн эрүүл мэндийн салбарын барилга, 8,919,7 сая төгрөгийн боловсрол соёл, спортын салбарын барилга, 809,5 сая төгрөгийн конторын зориулалттай барилга, 1,259,2 сая төгрөгийн орон сууцны бус бусад барилга, 5,651,6 сая төгрөгийн бусад зам талбайн ажил хийгдсэн байна.

XI. Аж үйлдвэр.

 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2015 оны жилийн эцсийн байдлаар 7542.6 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 18.8 хувиар өссөн байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 53.5 хувь буюу 4033.5 сая төгрөг нь уул уурхайн олборлох аж үйлдвэр, 14 хувь буюу 1059.2 сая төгрөг нь боловсруулах аж үйлдвэр, 32.5 хувь

буюу 2449.9 сая төгрөг нь цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж тус тус эзэлж байна.

XII. Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ, үнийн индекс



Хэрэглээний үнийн индекс нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нэг өрхийнхийг биш, нийт өрхөөр тооцсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна. Тус аймагт 2015 оны 12-р сарын байдлаар хэрэглээний үнийн индекс 2014 оны 12-

сартай харьцуулахад харьцуулахад 4,0 хувиар өсчээ.

Хэрэглээний үнийн индекс 4,0 хувиар өсөхөд хувцас бөс бараа гутлын бүлэг 8,0 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 10,9 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 6,2 хувь, боловсролын бүлэг 32.5 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур, байрны үйлчилгээний бүлэг 17,2 хувь бусад бараа үйлчилгээ 3,3 хувиар тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Тухайн сарыг өмнөх сарын үнийн мэдээтэй харьцуулахад 0,7 хувиар өссөн байна. 2015 оны 12 сарын байдлаар Сайнцагаан сумын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн бараа, бензин, дизель түлш болон ноолуурын үнийг орууллаа

№	Барааны нэр, төрөл	XII/2	XII/9	XII/16	XII/23	XII/30
1	Гурил, I зэрэг, кг	1280	1280	1280	1250	1250
2	Хонины мах, кг	3500	3800	4000	3500	3500
3	Үхрийн мах, кг	0	0	0	0	0
4	Ямааны ястай мах	3000	3000	3200	3000	3000
5	Элсэн чихэр, кг	1600	1600	1600	1600	1650
6	Цагаан будаа, кг	2200	2200	2200	2200	2230
7	Шингэн сүү, л	2500	2500	2500	2500	2500
8	Ноолуурын үнэ 1кг:- Цагаан	53000	53000	53000	53000	53000
	- Бор	53000	53000	53000	53000	53000


	- Холимог	53000	53000	53000	53000	53000
9	Бензин, А-80, 1 литр	1550	1550	1550	1550	1550
10	Бензин, А-92, 1 литр	1800	1800	1800	1800	1800
11	Дизелийн түлш, 1 литр	1880	1880	1880	1880	1880

X. Гэмт хэрэг



Цагдаагийн хэлтсийн 2015 оны жилийн эцсийн мэдээгээр аймгийн хэмжээнд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 242 болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад буурсан байна. Гэмт хэрэгт холбогдогсдын тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4,4 хувиар буурч 219 хүн холбогдоод байна. 2015 оны жилийн эцсийн байдлаар дээрэм, ашиглал, албан тушаал, гал түймэрийн гэмт хэрэг гараагүй байна. Өнгөрсөн оны мөн үеэс бусдын өмчийн хулгай 2,1 хувиар буурсаны дотор малын хулгай 24,4 хувиар буурсан, харин иргэдийн өмчийн хулгай 15,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Бүртгэгдсэн нийт хэргүүдийг өнгөөр нь авч үзвэл 28,9 хувийг бусдын бие махбодьд гэмтэл учруулсан, 38,0 хувийг хулгайн, 14,5 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 4,1 хувийг танхайрах, 2,9 хувийг залилан, 2,1 хувийг хүн амь, хүчин, золгүй учрал, булаалт, 9,5 хувийг бусад хэрэг тус тус эзэлж байна.



Нийт гэмт хэргийн 27,3 хувийг согтуугаар үйлдсэн байна. 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг аймгийн дүн 83 хүн байхад Дэлгэрцогт 186, Говь-Угтаал 125, Цагаандэлгэр 118, Сайнцагаан 125, Гурвансайхан 86 хүн байгаа нь гэмт хэрэг ихтэй сумдад орж байна.



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 801,5 сая төгрөг, түүний 7,3 хувь буюу 571,8 сая төгрөгийг нөхөн төлүүлээд байна.

XIV. Байгаль орчин



Дундговь аймгийн нутгаар 2016 оны 1 р сард цаг агаар ямар байх тухай урьдчилсан төлөв Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ

Энэ сарын агаарын температурын дундаж нь нутгийн баруун болон, зүүн хойд хэсгээр 17-22 градус хүйтэн бусад нутгаар 12-17 градус буюу нутгийн баруун хэсгээр олон жилийн дунджаас 1.0-1.5 градусаар дулаан, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй. Нэг ба хоёрдугаар арав хоногийн эхэн ба эцэс, гуравдугаар арав хоногийн эхээр хүйтний эрч суларч нутгийн хойд хэсгээр шөнөдөө 18-23 градус, өдөртөө 7-12 градус, бусад нутгаар шөнөдөө 14-19 градус, өдөртөө 3-8 градус хүйтэн байна. Харин гуравдугаар арав хоногийн дунд үеэр хүйтний эрч чангарч шөнөдөө 27-32 градус, өдөртөө 16-21 градус хүйтэн байна. Бусад хугацаанд ихэнх нутгаар шөнөдөө 21-26 градус, өдөртөө 11-16 градус

хүйтэн байна.Энэ сард нийт нутгаар олон жилийн дунджийн орчим цас орох төлөвтэй.

Нэгдүгээр арав хоногийн дунд үеэр нутгийн хойд хэсгээр, хоёр ба гуравдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар цас орж, цасан шуурга шуурах төлөвтэй.

Салхи нэг ба гуравдугаар арав хоногийн эхний хагас, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар 12-14 м/с хүртэл ширүүсэх төлөвтэй.